

# Судраас суралцах арга барил, ур чадвар

**Нэр орлуулалт:** Судрууд дээрх сургаал, зарчмуудыг өөрсдийн амьдралтай холбохын тулд сударт байгаа нэрийг өөрийн нэрээр орлуул. Судраас суралцах энэ чадварыг Матай 16:15–17 дээрх Петрийн нэрийг оруулан ашиглаж үз.

**Шалтгаан ба үр дагавар:** Судрууд дээрх сайн мэдээний зарчмуудыг олж тодорхойлохын тулд “хэрэв–тэгвэл” ба “учраас–тиймийн тул” гэсэн үгнүүдийн хоорондын харилцаа холбоог олж мэд. Энэ ур чадварыг Матай 6:14–15 дээр ашиглаж үз.

**Судрын жагсаалт:** Судруудад ихэвчлэн удирдамж эсвэл сэрэмжлүүлэг гэх мэт зүйлсийн жагсаалт орсон байдаг. Жагсаалтыг олсон бол тэнд орсон бүх зүйлийг дугаарлах тухай бодож үз. Энэхүү чадварыг Галат 5:22–23 дээр ашиглаж үз.

**Харьцуулалт:** Судрууд ихэвчлэн санаа зорилго, үйл явдал ба хүмүүсийг хооронд нь харьцуулдаг. Эдгээр харьцуулалт нь сайн мэдээний зарчмуудыг онцолдог юм. Номон дээрх шүлэг, судрын хэсэг, бүлгүүдэд байгаа харьцуулалтыг олж хар. Энэ ур чадварыг Матай 5:14–16 дээр ашиглаж үз.

**Төсөөлөл:** Уншиж байхдаа таны оюун ухаанд дүр зургийг төсөөлөн харахад туслах дүрслэн бичсэн тодорхойлолтуудыг олж хар. Зарим үйл явдалд өөрийгөө оролцож байгаагаар төсөөлөн бод. Энэ нь судраас уншсан зүйл үнэн бодитой гэсэн таны гэрчлэлийг хүчирхэгжүүлж чадна. Энэ ур чадварыг Матай 8:23–27 дээр ашиглаж үз.

**Бэлгэдэл:** *Адил, мэт* эсвэл *адилтгах* зэрэг үг нь бэлгэдлүүдийг олж тодорхойлоход танд тусална. Бэлгэдлийн мөн чанарыг судалж, шинж чанарынх нь талаар тунгаан бодох арга замаар бэлгэдлийн цаад утгыг олж хар. Зүүлт тайлбарууд, Bible Dictionary, Topical Guide эсвэл Судруудын удирдамж нь танд зарим бэлгэдлийг тайлбарлахад тусална. Энэ ур чадварыг Матай 13:24–30 дээр ашиглаж үз.

**Солбицсон эшлэл:** Ихэнх тохиолдолд судрын нэг хэсэг өөр судрын хэсгийн хэллэгийг юм уу утга агуулгыг тайлбарлаж эсвэл тодруулж өгдөг. Судрын шүлгийн утга агуулгыг тайлахын тулд судрын зүүлт тайлбар, индекс эсвэл Topical Guide эсвэл Судруудын удирдамж зэргийг ашиглан судрын шүлгүүдийг хооронд нь холбо. Уг ур чадварыг Иохан 10:16-г уншаад, дараа нь зүүлт тайлбар а дээрх 3 Нифай 15:21-ийг солбицсон эшлэл болгох дадлага хий. 3 Нифай 15:21-ийг унших нь Иохан 10:16-ийн утгыг илүү сайн ойлгоход танд хэрхэн тусалж байна вэ?

**Эргэцүүлэл:** Эргэцүүлэлд бодох, бясалгах, асуух, сурч мэдсэн зүйлсээ дүгнэх зэрэг нь орно. Байнга эргэцүүлэн бодож байх нь сайн мэдээний зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй болохыг ойлгоход бидэнд тусалдаг. Та Еврей 12:9 дээрх үнэнүүдийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар тунгаан бод.

**Хэрэгжүүлэлт:** Та судрууд дээрх сургаал, зарчмуудыг олж тогтоон, ойлгож авсны дараа, олж мэдсэн үнэнүүдийнхээ дагуу үйлдсэнээр илүү гүн гүнзгий мэдлэгтэй болж чадна. Есүс Христ “Хэрэв хэн нэгэн Түүний [Тэнгэрлэг Эцэгийн] хүслийг үйлдэхийг хүсэж байвал тэр нь энэ сургаал Бурханаас ирсэн үү, эсвэл Би Өөрөөсөө ярьж байна уу гэдгийг мэднэ” (Иохан 7:17) хэмээн хэлсэн. Судруудыг бие даан судлах үедээ олж мэдсэн зүйлээ амьдралдаа хэрэгжүүлэх боломжийг эрэлхийл.

